

ЖАН-ФРАНСУА ЛИОТАР
“ПОСТМОДЕРН ТӨЛӨВ: МЭДЛЭГИЙН ТУХАЙ ИЛТГЭЛ”
зохиолын хэсгээс

Долоодугаар бүлэг

Шинжлэх ухааны мэдлэгийн прагматик

Шинжлэх ухааны мэдлэгийн прагматикийн талаарх сонгодог үзэл баримтлалыг товчхон ч атугай тодорхойлон үзүүлэхийг оролдъя. Ингэх явцдаа судалгаа, сургалт гэсэн хоёр тоглоомыг ялгах болно. Гарагууд тойрог замаар эргэдэг гэж Коперник зарлажээ²⁰⁷. Үнэн эсвэл худал байх энэ өгүүлбэр нь тоглоомд оролцож буй илгээгч, хүлээн авагч, референт гэсэн прагматик байр тус бүрт тулгарах хэд хэдэн дарамтыг өөртөө агуулдаг. Эдгээр «дарамт» нь хэллэгийг «шинжлэх ухааны» гэж хүлээн зөвшөөрөх нөхцлийг зохицуулдаг олон янзын дүрэм юм.

Нэгд, илгээгч нь референтийн талаар, бидний жишээ дээр бол гарагийн явах замын тухай үнэнийг хэлэх ёстой. Энэ нь түүнийг нэг талаас ярьж байгаа зүйлдээ нотолгоо гаргах, нөгөө талаас тухайн референтийн талаарх эсрэг буюу зөрчилдөх бүх хэллэг худлаа гэдгийг нотлон үзүүлэх чадвартай байх ёстой гэсэн утгыг заана.

Хоёрд, хүлээн авагчийн хувьд ч сонссон тухайн хэллэгээ хүлээн зөвшөөрөх эсвэл няцаах боломж байх ёстой. Энэ нь тэр өөрөө бололцоот илгээгч мөн гэдгийг, иймд Коперникийн нэгэн адил дээрх хоёр (нотлох эсвэл үгүйсгэх) шаардлагад захирагдана гэдгийг илэрхийлнэ. Хүлээн авагч нь Коперникийнх шиг шинжийг бололцоо байдлаар агуулж байх учиртай тул тэр хоёр тэнцүү. Гэхдээ энэ нь түүнийг ярьж эхэлсэн үед л мэдэгдэнэ. Үүнээс урьд түүнийг шинжлэх ухааны судлаач мөн эсэхийг хэлэх боломжгүй.

Гуравт, Коперникийн ярьж буй референт (гарагийн зам) байгаа байдалтайгаа тохирч хэллэгт “илэрхийлэгдэх” ёстой. Гэвч тухайн референт ямар болохыг Коперникийнхтэй ижил эрэмбийн хэллэгээр л мэдэх боломжтой болохоор адилсалын энэхүү дүрэм нь асуудалтай юм. Ямар болохыг нь би нотлож байгаа учраас миний ярьж байгаа үнэн, гэтэл миний нотолгоо үнэн гэдгийг юу нотлох вэ?

Тухайн бэрхшээлийн «шинжлэх ухаанч» шийдэл доорх хоёр дүрэмд захирагддаг. Эхнийх нь, диалектик буюу хуулийн утгаар риторик шинжтэй²⁰⁸: референт бол нотлогдохуйц, мэтгэлцээнд баримт болох зүйл мөн. «Бодит байдал яг миний хэлсэнчлэн байгаа учраас би үүнийг нотлож байна» гэхгүй, харин «би үүнийг нотлож чадах учраас бодит байдал миний хэлсэнчлэн байна гэж бодож болно»²⁰⁹. Нөгөө нь, метафизик маягийн дүрэм: нэг референтээс зөрчилтэй буюу үл нийцэх олон тооны нотолгоо гарахгүй. Үүнийг өөрөөр «Эзэн тэнгэр хуурамч биш»²¹⁰ хэмээн илэрхийлдэг.

Эл хоёр дүрэм нь XIX зууны шинжлэх ухаан верификаци гэж, XX зууны шинжлэх ухаан фальсификаци гэж нэрлэсэн зүйлийн үндэс болсон²¹¹. Эдгээр дүрэм илгээгч, хүлээн авагч хоорондын мэтгэлцээнд зөвшилцлийн хүрээ бий болгодог.

²⁰⁷ Энэ жишээг Фрэгэгийн “*Über Sinn und Bedeutung*” (1892) бүтээлээс авлаа.

²⁰⁸ Bruno Latour and Paolo Fabbri, “*Rhétorique de la science*,” *Actes de la recherche en sciences sociales* 13 (1977): 81-95

²⁰⁹ Gaston Bachelard, *Le Nouvel Esprit Scientifique* (Paris: Presses Universitaires de France; 1934).

²¹⁰ Descartes, *Méditations métaphysiques* (1641), Méditation 4.

²¹¹ Жишээ нь Karl G. Hempel, *Philosophy of Natural Science* (Englewood Cliffs, N.J.: Prentice-Hall, 1966)-г үз.

Зөвшилцөл бүр үнэний илэрхийлэл байж чадахгүй ч хэллэгийн үнэн нь зөвшилцлийг гарцаагүй дагуулдаг гэж ойлговол зохилтой.

Энэ нь судалгааг хамаарна. Судалгаа өөрийг нь зайлшгүй нөхөн гүйцээгч сургалтыг шаарддаг. Учир нь эрдэмтэн хүнд өөрийн ээлжинд илгээгч болж чадах хүлээн авагч хэрэгтэй, түүнд хамтрагч хэрэгтэй. Тиймгүйсэн бол түүний хэллэгийг шалгах боломжгүй байхсан, учир нь шаардлагатай чадваруудыг үл шинэчлэх нь эцэстээ зөрчилт маргаанд гарцаагүй хүргэнэ. Эрдэмтэн хүний хэллэгийн үнэн төдийгүй эрдэмтний чадвар ч энэ маргааны бай болно. Хүний чадвар хэзээ ч бүрэн төгс баримт болдоггүй. Энэ нь дэвшүүлсэн хэллэгийг үндэслэгээ, няцаалтын жагсаалтанд үнэтэй санал болсон гэж зиндаа нэгтнүүд нь тооцох эсэхээс хамаарна. Хэллэгийн үнэн хийгээд түүнийг илгээгчийн чадвар ийнхүү ижил түвшний чадвар бүхий бүлэг хүний хамтын сайшаалаас хамаарна. Эн тэнцүүчүүд хэрэгтэй бөгөөд тэднийг бүтээх ёстой.

Сурган заах арга ийм нөхөн үйлдвэрлэлийг хангадаг. Тэр нь судалгааны диалектик тоглоомоос ялгаатай. Товчхондоо бол түүний анхдагч урьдач нөхцөл хэллэгийг хүлээн авагч буюу оюутан илгээгчийн мэдэж байгааг мэдэхгүйд оршино, чухам иймд түүнд сурах зүйл байна. Дараагийн урьдач нөхцөл нь оюутан илгээгчийн мэддэг зүйлийг сурч, багштайгаа тэнцүү хэмжээний чадавхитай шинжээч болж чадна гэдэгт бий ²¹². Энэ хос шаардлага гуравдахийг буюу судалгааны прагматикийг бүрдүүлэгч хангалттай хүлээн зөвшөөрөгдсөн нотолгооны боловсруулалт, үндэслэгээний солилцоо бүхий хэллэгүүд байдаг, иймд тэднийг байгаагаар нь маргаангүй үнэн мэтээр дамжуулан заахыг нөхцөлдүүлдэг.

Өөрөөр хэлбэл та мэдэж байгаагаа заана: шинжээч бол ийм юм. Гэхдээ оюутан (сурган заах үйл явцын хүлээн авагч) ур чадвараа нэмэгдүүлэхийн хэрээр шинжээч мэдэхгүй ч мэдэхийг хичээдэг зүйлээ (ядаад тэр шинжээч судалгаа хийдэг бол) түүнд дэлгэн хэлнэ. Ингэж оюутан судалгааны диалектикт, өөрөөр хэлбэл шинжлэх ухааны мэдлэг үйлдвэрлэх тоглоомд татагдан орно.

Энэ шинжлэх ухааны прагматикийг нарратив мэдлэгийнхтэй харьцуулаад дараах онцлогуудыг бид тэмдэглэж болохоор байна.

1. Шинжлэх ухааны мэдлэг хэлний нэг л тоглоомыг буюу денотативыг үлдээж, бусдыг нь хасахыг шаарддаг. Хэллэгийг хүлээн зөвшөөрөх эсэхийн гол шалгуур нь хэллэгийн үнэний утга болно. Хэллэгийн бусад төрөл буюу асуултан (...гэдгийг яаж тайлбарлах вэ?), прескриптив (...элементүүдийн тоологдом дараалал байг) гэх мэт хэллэгтэй тааралдаж болох ч тэд денотатив хэллэгээр л төгсөх учиртай диалектик үндэслэгээний шийдвэрлэгч цэг болж илэрдэг²¹³. Энэ нөхцөлд тэгэхлээр референтийн тухайд үнэн хэллэг бүтээж чадваас тэр хүн "эрдэмтэй", референтийн талаар шинжээчдэд хүртээлтэй нотлогдохуйц эсвэл няцаагдахуйц хэллэгүүд томъёолж чадвал эрдэмтэн мөн.

1. Шинжлэх ухааны мэдлэг энэ утгаараа нийгмийн холбоосыг хослон бүрдүүлдэг хэлний тоглоомуудаас тусдаа бүтээгддэг. Нарратив мэдлэгээс ялгаатай нь тэрээр энэхүү холбоосын шууд, нийтлэг бүрэлдэхүүн байхаа больсон. Гэхдээ дам байдлаар үүний нэг бүрдэл болно, учир нь тэрээр мэргэжил болтлоо хөгжиж, институтууд

²¹² Ийм хос урьдач нөхцлөөс үүдэх бүх бэрхшээлийг энд авч үзэхгүй. Энэ асуудлаар Vincent Descombes, *L'Inconscient malgré lui* (Paris: Editions de Minuit, 1977)-г үз.

²¹³ Хүүрнэлийн судалгаанд ч үүсч болох том бэрхшээлийг энэ ажиглалт далдалдаг. Энэ нь хэлний тоглоом, дискурсын төрөл хоорондын ялгаанд байгаа юм. Үүнийг энд авч үзсэнгүй.

төрүүлсэн, тэгээд ч орчин үеийн нийгэмд хэлний тоглоомууд өөрсдийгөө мэргэжсэн тоглогчдоор (мэргэжлийн бүлгээр) удирдуулдаг институт маягаар бэхжиж байна. Мэдлэг, нийгэм (өөрөөр хэлбэл мэргэжлийн албан тушаалдаа байгаа эрдэмтдийг хасаад өргөн хүрээний тэмцэлдээнд байгаа нийт тоглогч) хоорондын харилцаа хаа хаанаа хөндий болжээ. Шинэ асуудал үүслээ. Энэ нь шинжлэх ухааны институт, нийгэм хоёрын харилцааны асуудал юм. Уг асуудлыг сурган заах арга зүйгээр жишээлбэл, нийгмийн аливаа атом шинжлэх ухааны чадавхийг эзэмшиж чадна гэсэн угтвар нөхцлөөр шийдэж болох уу?

2. Судалгааны тоглоомын хүрээнд шаардагдах чадавхи нь зөвхөн илгээгчид хамаатай. Хүлээн авагчаас онцгой чадавхи шаардахгүй (оюутан ухаалаг байх ёстой гэдгийг зөвхөн сургалтанд шаардана). Түүнчлэн референтэд ч ямар нэг чадавхи шаардагдахгүй. Хүний үйлдлийг судалдаг хүмүүнлэгийн шинжлэх ухаануудын тухайд ч референт нь зарчмын хувьд шинжлэх ухааны диалектикт оролцдог тоглогчдынхоо гадна байна. Энд нарратив тоглоомтой харьцуулахад хэн нэг хүн мэдлэгийн өгүүлж буй зүйл хэрхэн түүний тухай болж байгааг мэдэх шаардлагагүй.

1. Шинжлэх ухааны хэллэг зарлан мэдэгдсэн гэдгээсээ хүчин төгөлдөр шинжийг олдоггүй. Сурган заах тохиолдолд ч гэсэн түүнийг үндэслэгээ, нотолгоогоор тухайн агшинд шалгаж болох учраас л зааж буй юм. Байгаагаараа тэрээр «няцаагдах» аюулаас хэзээ ч ангижрахгүй²¹⁴. Иймд нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн хэллэг болж хуримтлагдсан мэдлэг нь үргэлжид сорилтонд байна. Нөгөөтэйгүүр тухайн референтийн тухай өмнө нь хүлээн зөвшөөрөгдсөн хэллэгт зөрчилдөх, аливаа шинэ хэллэг нь үндэслэл, нотолгоогоор өмнөхийг няцааж байж л хүчин төгөлдөр болж хүлээн зөвшөөрөгдөж чадна.

2. Шинжлэх ухааны тоглоом иймд диахрон хэмнэлт шинж өөрөөр хэлбэл ой санамж болон төслийг агуулдаг. Шинжлэх ухааны хэллэгийг илгээгч нь референтэд холбогдох өмнөх хэллэгүүдтэй (номзүйтэй) танилцсан байх ёстой бөгөөд өмнөх хэллэгүүдээс ялгаатай байх тохиолдолд л шинэ хэллэгийг дэвшүүлнэ. Гүйцэтгэл бүрт «өргөлт» гэж миний нэрлэсэн, тоглоомын шүүмжлэлт функцийг бэлгэддэг тэр зүйл энд «хэмжээ»-нээс чухалд тавигддаг. Ой санамж ба шинийн эрэл хайгуулыг илэрхийлэх энэ диахрон шинж зарчмын хувьд кумулятив үйл явцыг илтгэдэг. Үүний "хэмнэл" буюу өргөлт, хэмжээ хоорондын харилцаа нь хувирамтгай.²¹⁵

Дурдсан шинжүүд мэдээжийн. Гэхдээ хоёр шалтгаанаар тэднийг ахин авч үзэх хэрэгтэй. Нэгд, шинжлэх ухаан ба шинжлэх ухааны бус (нарратив) мэдлэгийг зэрэгцүүлэн авч үзэх нь шинжлэх ухааны оршихуйн зайлшгүй шинж шинжлэх ухааны бус мэдлэгийнхээс илүүгүй, гэхдээ бас дутуугүй гэдгийг ойлгоход, ядаад мэдрэхэд маань тус болно. Аль аль нь хэллэгийн олонлогоос бүрддэг; хэллэгүүд нь нийтлэг хэрэглэгдэх дүрмийн хүрээнд тоглогчдын хийсэн «нүүдэл» юм; мэдлэгийн тухайн төрөл бүрийн хувьд дүрэм өвөрмөц байх бөгөөд нэгд нь "сайн" гэж тооцогдох «нүүдэл» санамсаргүй давхацлыг үл тооцвол нөгөөд нь тийм байх боломжгүй.

Иймд нарратив мэдлэгийн оршин байхуй, хүчин төгөлдөр шинжийг шинжлэх ухааны мэдлэгийн үүднээс шүүн хэлэлцэх боломжгүй, эсрэгээрээ мөн адил яагаад гэвэл тохирох шалгуурууд нь ялгаатай. Ургамал, амьтны олон төрөл зүйлийг гайхан биширдэг шигээ дискурсын олон янз төрөл зүйлийг мөн гайхан ширтэх нь бидний хийж чадах ганц зүйл. Постмодерн үед «утга алдагдсанд» харуусах нь мэдлэг зарчмын

²¹⁴ 5 дугаар зүүлтэнд тодорхойлсон утгаар.

²¹⁵ Thomas Kuhn, *The Structure of Scientific Revolutions* (Chicago: University of Chicago Press, 1962).

хувьд нарратив байхаа больсонд гашуудах гашуудал болон даамжирч байна. Заавал ч ингэх албагүй. Шинжлэх ухааны мэдлэг нарратив мэдлэгт үр хөврөл байдлаар агуулагдаж байсан юм шиг эхнийхийг удаахаас нь (хөгжил гэх мэт операторууд ашиглан) үүсгэн гаргах гэж оролдох хэрэггүй.

Юутай ч хэлний төрөл зүйлүүд амьтны төрөл зүйлүүд шиг харилцан холбоотой агаад энэ харилцаа тэр бүр нийцтэй байдаггүй. Шинжлэх ухааны хэлний тоглоомын онцлог шинжийг ийн ахин дурдсанаа зөвтгөх хоёр дахь шалтгаан мэдээж нарратив мэдлэгт хандах түүний харилцаанд хамаатай. Нарратив мэдлэг хуульчлалын асуудалдаа онцгой ач холбогдол өгдөггүйг, тэрээр үндэслэл юмуу нотолгоонд хандалгүйгээр уламжлан дамжих прагматикаараа өөрийгөө баталгаажуулдагыг түрүүн өгүүлсэн. Шинжлэх ухааны дискурсын асуудлыг үл ойлгох түүний байдал тодорхой хүлцэлийг шаарддагийн шалтгаан энэ билээ: тэрээр ийм дискурст нарратив соёлын бүл дэх нэг төрөл зүйл хэмээн ханддаг²¹⁶. Шинжлэх ухааны талаас бол тийм биш. Эрдэмтэд нарратив хэллэгийн хүчин төгөлдөр шинжийг байцааж, түүнийг үндэслэл, нотолгоонд хэзээ ч хамаарахгүй хэмээн дүгнэдэг²¹⁷. Тэд нарратив хэллэгүүдийг зэрлэг, бүдүүлэг, бүрэн боловсроогүй, хоцрогдсон, харийн, санаа бодлоос бүрдсэн, зан заншил, нэр хүнд, өнгөц төсөөлөл, үл мэдэхүй, үзэл суртал хэмээн өөр менталитэдэд хамааруулан ангилдаг. Нарративууд бол хүүхэд, эмэгтэйчүүдэд л таарах, зохиомол үлгэр, домог. Сайндаа л иргэншүүлж, боловсруулж, хөгжүүлэхийн тулд энэ харанхуй байдалд гэрэл гэгээ тусгахаар хийж буй оролдлого юм.

Ийм тэгш биш харилцаа нь тоглоом бүрт өвөрмөц байх дүрмүүдийн дотоод нөлөөнөөс үүдэлтэй. Үүний шинж тэмдэгийг бид бүгд мэднэ. Энэ бол Өрнөдийн иргэншлийн үүслээс эхтэй соёлын империализмын бүхэл бүтэн түүх. Империализмын бусад бүх хэлбэрээс ялгарах түүний онцгой аясыг ойлгох нь чухал: энэ нь хуульчлалын шаардлагад захирагддаг.

²¹⁶ Шинжлэх ухааныг анхлан оролдох буй хүүхдийн хандлага болон угсаатны зүйчдийн тайлбарыг тайлбарлаж байсан уугуул иргэдийн хандлагын тухай Claude Lévi-Strauss, *La Pensée sauvage* (Paris: Plon, 1962) бүтээлийн I бүлгээс үз.

²¹⁷ Мэтро "Болхи нийгмийг судлах боломжийн төлөө эл нийгэм бага зэрэг доройтох хэрэгтэй" хэмээн Кластрэст санал болгосоны цаад шалтгаан энэ билээ. Үнэндээ мэдээ цуглуулагч нутгийн уугуул хүн өөрийн нийгмээ угсаатны зүйчийн нүдээр харж чаддаг байх ёстой: тэрээр нийгмийн институтуудын үүрэгжилт ингэхлээр тэдний хууль ёсны шинжийг судлан шинжлэх чадвартай байх ёстой. Ахэ овгийн тухайд бүтэлгүйтсэнээ эрэгцүүлээд Кластрэс "Ахэчүүд гачигдаж зовох юмгүй зэгсэн тэнхлүүн хүмүүс учраас гуйгаагүй бэлгээ авах бүртээ ярилцахаас татгалздаг тул ядарч зүдэрсэн цагт нь тэдэнтэй ярилцаж болох юм байна" гэсэн дүгнэлт хийжээ (Cartry M. "Pierre Clastres." *Libre 4* (1978)-с эшлэв).